



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 02 сарын 04 өдөр

Дугаар Б/М

Улаанбаатар хот

Сэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.3 дахь заалт, "Хөдөлмөрийн тухай" хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баясгалан овогтой Пүрэвсүрэнг Хан-Уул дүүрэг, Сүхбат овогтой Чулуундоржийг Баянзүрх дүүрэг, Баянжаргал овогтой Билэгсайханыг Сонгинохайрхан дүүрэг хариуцсан гэрээт ажилтнаар 2013 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай түр томилон ажиллуулсугай.

2. Тус гэрээт ажилчдын сарын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээний дагуу /ТҮ 3-4/ 374.948 /гурван зуун далан дөрвөн мянга есөн зуун дөчин найм/ төгрөгөөр тогтоож олгохыг нягтлан бодогч /П. Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Гэрээт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хяналт тавин холбогдох дүрэм, журмыг мөрдүүлэн ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Ч.Цог/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.БАТСАЙХАН

